



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 46267

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар дүгнэлтийн дагуу Шаардлага хангасан сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх тендерийн 1 дүгээр багц Шахмал түлшний шуудай нийлүүлэх тендерийг 220,000,000 (хоёр зуун хорин сая) төгрөгөөр Алхими ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 3 дугаар багц Авто ачигч 3 метр куб шанагатай, 4 дүгээр багц Сэрээт авто ачигч, 5 дугаар багц Шахмал түлш түгээх машин, 6 дугаар багц Түлш шигшиж, жинлэж, савлах төхөөрөмж нийлүүлэх багцуудыг хүчингүй болгосугай.

3. Тендерт шалгарсан аж ахуйн нэгж болон хүчингүй болсон багцуудад гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

4. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



6223 11 • 501

D:My Doc. Zahiramj. Zasag darga